

**“УЛААН САН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 5 дугаар сарын 25 өдөр
Увс аймаг, Баруунтуруун сум
09 цаг 15 минут

Хуралд хүрэлцэн ирэгээдийг бүртгэх бүртгэл 08 цаг 30 минутас эхлэв.

Хурал зохион байгуулах комисс: Хурлын ирцийг бүртгэж дуусаад ирцийг танилцуулж хурлын ирц бүрдсэн тухай тайлагнаж тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Хурлын дарга: Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн ирцийн талаархи мэдээллийг хийж тогтоолоо танилцуулна уу.

Тооллогын комисс: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийг 08 цаг 30 минутанд эхэлж 09 цаг 15 минутанд хааж ирцийн бүртгэлийг гаргалаа.

Нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 46072 ширхэг буюу 74.09 хувийн ирцтэй байна.

Хувьцаа эзэмшигчдийн ирц холбогдох хууль, журам, дүрмийн шаардлагыг хангаж байгаа тул хурлыг эхлүүлэхийг хурлын даргад мэдэгдэж байна.

Хурал хуралдсан огноо: 2023 оны 05 дугаар сарын 25 өдөр

Хаана: Увс аймаг, Баруунтуруун сум, Соёлын товийн байранд.

Хурлын дарга: Г.Лхагвасүрэн

Хурал эхэлсэн хугацаа: 09 цаг 15 минутанд

Хурлын ирц:

1. Г.Лхагвасүрэн /ОА89032911/-39724 ширхэг буюу 63.88 хувь
2. “Тулгат Чандмань баян” ХХК /4000471/-6348 ширхэг буюу 10.21 хувь

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ - ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан, 2023 оны төсөв төлөвлөгөөг хэлэлцэж батлах
3. Ногдол ашиг хувиарлахгүй тухай төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг танилцуулах
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найрууллагыг хэлэлцэж батлах.
5. Асуулт, хариулт болон бусад

Хурлын дэг:

1. Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гаргаж тооллогын комисс тогтоолоо танилцуулах -5 минут
2. Хурлыг нээж хурлын дарга Г.Лхагвасүрэн үг хэлэх -2 минут
3. Хурлын дэгийг танилцуулах -3 минут
4. Компанийн үйл ажиллагааны тайлан, түүнд өгсөн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт 10 минут
5. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайланд өгсөн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт /5 минут/
6. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах /2 минут/
7. Компанийн дүрмийн шинэчилсэн найрууллагыг хэлэлцэж батлах /цаг тогтоохгүй/
8. Завсарлага, санал тоолж нэгтгэх /10 минут/
9. Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг танилцуулах /5 минут/

Хурлаас гарах шийдвэр (тогтоол)-ыг хэлэлцэж батлах

Хурлын дарга: За та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өмнөх хурлын ирц хүрэхгүй байсан улмаас хойшлогдсон . Өвлөх эрх нээгдээгүй байсан учир хойшлошдоод сая хувьцаа өвлөгдөж өнөөдөр хурлаа хийж байна .

Ингээд манай хурал саяхан бас хуралдсан байгаа. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх эхний асуудал компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд өгсөн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах байгаа. Та бүхэнд тараагдсан материалаас асуух зүйл байвал асуугаарай.

Б.Батсайхан: Асуух зүйл алгаа.

Г.Лхагвасүрэн: Надад бас алгаа. Тэгэхээр энэ асуудлыг батлах уу?

Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.

Хурлын дарга: За дараагийн асуудал та бүхэнд ногдол ашиг хувиарлахгүй тухай шийдвэрийг ТУЗ-ийн дарга танилцуулна.

ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга: Дараагийн асуудал ТУЗ-ийн тайлан, 2023 оны төсвийг хэлэлцэж батлах. Манай компанийн гол хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн нэг гишүүн нас барсан тул оны өмнө ээлжит бус хурал зарлаад ТУЗ-ийн гишүүдийг сонгож баталсан байгаа. ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн дарга тайлангаа тавина.

Ц.Энхцаг: Өнгөрсөн онд компанийн ТУЗ-ийн зүгээс үйл ажиллагааг тогтворжуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх талаар нэлээд хүчин чармайлт гаргасан хэдий ч бидний хүссэнээр болсонгүй ээ.

2022 онд манай компанийн ТУЗ-ийн үйл ажиллагаа нь хэвийн явагдсан гэж дүгнэж байна.

Цаашид Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийхаа үйл ажиллагааг сайжруулах талаар дорвитой ажиллах байхаа гэж найдаж байна. Энэ онд буюу 2023 онд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулалын асуудал бас хүнд байгаа учир гишүүдийг цалинжуулахгүй гэсэн шийдэлд хүрсэн ба бичиг хэргийн зардлыг компанийн зүгээс шийдвэрлэх нь зүйтэй байна.

Цаашид бидний хэрэгжүүлэх гол ажлууд:

1. Компани нь үрийн чанарыг нэмэгдүүлж аургац өндөртэй үр гаргаж авахаар тууштай ажиллах. Энэхүү ажлыг хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тодорхой хэмжээний лабораторитай хамтарч ажиллах шаардлагатай байна.
2. Мөн техник нэмж ажиллуулсанаар хүний хүчин зүйлийн нөлөөлөл буурах хэдий ч мэргэжлийн хүмүүсийг авч ажиллуулах. Орон нутгийн иргэдтэй гэрээ хийж ургац хуураалтанд ажиллуулсанаар богино хугацаанд ургац алдалгүйгээр бүрэн хураан авах боломж бүрдэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт байна уу?

Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тайлан болон 2023 оны төлөвлөгөөг батлав.

Хурлын дарга: Дараагийн асуудал нь компанийн дүрмийн шинэчилсэн найрууллагыг хэлэлцэж батлах тухай.

Г.Лхагвасүрэн: Манай компанийн дүрэм нь 1995 оны дүрмээрээ улсын бүртгэлийн байгууллагад байдаг юм байна. Тэгээх улсын бүртгэлээс өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулинд нийцүүлж дүрмээ шинэчил гэсэн шаардлагын дагуу дүрмийг шинэчилсэн. Ер нь бол Монгол улсын компанийн тухай хуулийн дагуу шинэчлэн боловсруулсан ба ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаагаар сонгоно гэсэн заалт нэмэгдсэн бусдаар бол хуучнаасаа агуулгын хувьд өөрчлөгдөөгүй байгаа. Та бүхэнд

"УЛААН САН" Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл

тараагдсан материалд дүрмийг эх хувиар нь оруулсан байгаа тул шууд ярилцаад батлаад явах уу?

Хуралд оролцогсод 100% дэмжсэн тул дүрмийн шинэчилсэн найрууллагыг батлав.

Хурал 12 цаг 05 минутанд өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн *Д.Лхамаахүү* Д.Лхамаахүү

Хурлын тэмдэглэл нийт 4 /дөрөв/ хуудас